

МАЛ, АМЬТНЫ ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ЗААВАР

1. Тодорхойлолт: Шүлхий нь богино хугацаанд өргөн уудам нутгийг хамран тархаж, тэмээ, үхэр, сарлаг, хонь, ямаа, гахай, буга, зээр зэрэг салаа туурайтныг өвчлүүлдэг вирусын гоц халдварт өвчин юм. Шүлхийгээр өвчилсөн нас гүйцсэн малын үхэл хорогдол бага, харин нялх төл болон ядарч доройтсон мал, амьтан олноор үхэж хорогддог.

2. Өвчний үүсгэгч: Шүлхий өвчнийг үүсгэгч вирус нь Пикорновиридэ ангийн Афтовирүс зүйлд хамаарна. Шүлхийн вирус нь А, О, Ази-1, С, САТ-1, САТ-2, САТ-3 гэсэн дархлаа төрүүлэх чанараараа өөр долоон хэвшил байх ба тэдгээрийн дотор 60 гаруй дэд хэвшил тодорхойлогджээ. Гэвч шүлхий өвчин байнга гардаг нутагт цөөн хэдэн дэд хэвшлээр өвчин үүсдэг. Шүлхийн вирусын аль нэг хэвшлээр өвчилсөн мал, амьтан бусад хэвшлээр өвчлөх магадлалтай.

Үүсгэгчийн тэсвэрт чанар: Шүлхийн вирус нь устөрөгчийн ионы төвшрүүлгийн (рН) өөрчлөлтөд мэдрэг тул түүнийг 6 - аас доош эсвэл 9 - өөс дээш рН бүхий орчинд үйлчлүүлэхэд идэвхээ алдана. Мах загссаны дараа түүний рН 6-аас доош болоход шүлхийн вирус идэвхгүйжих ба харин ясны чөмөг, тунгалгийн зангилаанд вирус удаан амьдарна. Орчны хэм, нарны гэрэл, чийг, рН төвшрүүлгээс хамаарч шүлхийн вирус гадаад орчинд нэг сар хүртэл халдварлах чадвартай байна. Цууны хүчлийн 2 хувийн уусмал, нимбэг хүчлийн 0, 2 хувийн уусмал зэрэг хүчиллэг эсвэл идэмхий натрийн 2 хувийн эсвэл карбонат натрийн 4 хувийн уусмал зэрэг шүлтлэг уусмалд шүлхийн вирус тэсвэргүй бол иодын нэгдэл, хлорын шохой, фенол, аммонийн нэгдэлд шүлхийн вирус харьцангуй тэсвэртэй.

3. Халдвар дамжих зам: Халдварын голомт нь өвчтэй, өвчлөөд эдгэрсэн, халдвар авсан мал, амьтан, тэдгээрийн нус, шүлс, шээс, баас, сүү, үр зэрэгтэй хамт ялгаран гарсан вирусээр бохирлогдсон уяа, зогсоол, хашаа саравч, өтөг, бууц, ус, тэжээл, бэлчээр, мал, амьтны тоног хэрэгсэл, гутал хувцас зэрэг болно. Ихэнхдээ шүлхийн халдвар өвчтэй, халдвартай мал амьтнаас шүлхийд мэдрэг мал, амьтанд шууд хавьтлын замаар болон шүлхийн вирусээр бохирлогдсон зүйлээр дамжин тархах бөгөөд өвчний голомтод ойр байсан мал, амьтанд амьсгалын замаар халдаж болно. Чийглэг, бүрхэг, хүйтэн цаг агаартай үед шүлхийн вирус алс хол салхиар зөөгдөн халдварлах боломжтой.

Шүлхий өвчтэй малтай харьцан ажиллаж байсан хүний багалзуурын салсанд шүлхийн вирус түр хадгалагдаж халдвар тараах эрсдэлтэй тул голомтоос гарснаас хойш 3-5 хоног мал, амьтантай газар очихыг хориглоно.

4. Эмнэл зүйн шинж тэмдэг: Өвчний нууц үе ихэнхдээ 3-5 хоног ба заримдаа 21 хоног хүрдэг. Шүлхийгээр өвчилсөн мал, амьтны ам, хамар, буйл, тагнай, завьж, хэл, дэлэн хөх, турууны салааны арьсанд үлхий, яршил үүсэх, доголох, ус, тэжээлдээ дургүй болох, халуурах шинж тэмдэг илэрнэ.

Үхэр. Шүлхийрсэн үхэрт эхлээд 39.4-40.6⁰С хэм халуурах, номойрох, тэнцвэрээ алдах, тэжээлдээ дургүй болох, сүү нь татрах шинж илэрнэ. Шүлс нь гоожих, урсах, хамраас нь шингэн гоожих, хөлөө савлах, тийрэх эсвэл доголох, үлхий үүсэх шинж дагалдана. Ихэвчлэн хэл, буйл, жавьж, зөөлөн тагнай, хамрын толио, турууны салаа, турууны титэм, хөхөн дээр үлхий үүснэ. Үлхий ил харагдахгүй гарах нь бий. Үлхий үүссний дараа шүлс нь мэдэгдэм ихсэж хамраас нь шингэн урсах, мөн доголох шинж зэрэгцэнэ. Үнээ хээл хаях, нялх тугал үлхий үүсэхийн зуургүй үхэж болно. Шүлхий өвчин 2-3 долоо хоног үргэлжилнэ. Хоёрдогч халдвараас шалтгаалан эдгэрэлт удааширч болно. Дэлэнгийн эдийн гэмтлээс шалтгаалан саалийн малын сүү эрүүл үеийнхээсээ татарна.

Гахай. Эхлээд 40-40.6⁰С халуурч, тэжээлдээ дургүй болон хөдөлгөөн нь удааширна. Дараа нь турууны титэм, өсгий, турууны салаа, хоншоороор нь үлхий гарна. Амны хөндийд гэмтэл гарах нь нийтлэг биш ч хэрэв гарвал хэмжээ нь бага, үхрийг бодвол хурдан эдгэрэх “хуурай” хэлбэрийн гэмтэл үүснэ. Харин шүлс гоожихгүй. Мэгж хээл хаях, торой ямар нэгж шинж тэмдэггүйгээр үхэх нь бий.

Хонь, ямаа. Шүлхийн вирусийн халдвар авсан хонь, ямаанд эмнэл зүйн шинж тэмдэг, хувиралт маш бүдэг буюу номойрох, буйл, уруул, жавьж, хэлэн дээр жижиг хэмжээтэй үлхий гарах байдлаар илэрнэ. Доголох нь бог малын шүлхийн гол шинж юм. Доголсон малын турууны титэм эсвэл салаанд нь үлхий, шархлаа үүссэн байж болно. Халдвар авсан мал хээл хаях, хөхүүл хурга ямар нэг шинж тэмдэггүйгээр үхэх нь бий.

Тэмээнд илрэх шинж тэмдэг үхрийнхтэй төстэй бөгөөд хүндэрсэн үед тэмээний ширмэн таваг, өвчүүний бүдэрхийн сайр хуурах, алтан хумс унах шинж тэмдэг ажиглагдана.

Шүлхийгээр халдварласан үхэрт өвчний шинж тэмдэг, хувирал гахай, хонь, ямааг бодвол илүү түргэн, хүндээр илэрнэ. Шүлхийн халдварт үхэр, гахай, хонь нэгэн зэрэг өртөхөд үхэр түрүүлж өвчилнө. Тэдгээрийн зарим нь шүлхийн вирус тээгч болно. Хивэгч ихэнх амьтад багалзуурынхаа эдэд шүлхийн вирусыг удаан хугацаанд хадгалж болно. Өвчилж өнгөрсөн эсвэл дархлаажсан үхэр өвчтэй мал, амьтантай хавьтах нөхцөлд өөрөө шинж тэмдэг үзүүлэхгүй ч вирусийг 6-24 сар тээж болно. Хонь шүлхийн вирусийг 4-6 сар тээнэ.

5. Эмгэг бие бүтцийн хувиралт: Үхрийн ам, багалзуур, залгиурын цочмог салст үрэвсэл, салст бүрхүүл, усавхи бүрхүүлийн дорх цус харвалт болсон байна. Амны хөндий, залгиур, улаан хоолой, сархинаг, гүзээ, хамрын толио, уруул, хөх, туруу, турууны салаанд үлхий, шархлаа, яр үүссэн байна. Ходоод, 12 хуруу гэдсэнд олон тооны цус харвалт үүссэн байхын дээр салст бүрхүүлийн цусархаг, салст, усавхи үрэвсэл юм уу цус ихдэж хавагнасан байна. Уушгинд тогтонгишнолын цус ихдэлт, хаван үүссэн байдаг бол хөлөнд үлхий, шархлаа үүсэж үрэвсэнэ. Дэлэн дээр үлхий үүсэх ба хүндэрсэн үед идээт үрэвсэл болно. Ил харагдах тунгалгийн зангилаа томорч цус ихдэлт болсон байна.

Хорт хэлбэрийн үед зүрх, их биеийн булчинд сөнөрлийн, үхжлийн шаргалдуу өнгөтэй голомтууд үүсдэг бол зүрхний булчинд цагаан судлууд үүсэх бөгөөд “баран зүрх” гэж нэрлэдэг. Хөл, нуруу, хавирганы завсар, хэлний булчингууд гэмтсэн байна.

Тугал, торой, хурганд ходоод, гэдэсний усавхи цусархаг үрэвсэл, заримдаа “баран зүрх” илэрнэ. Бусад төрлийн мал, амьтанд ч үхэрт илэрсэнтэй адил эмгэг хувиралт ажиглагдана.

6. Онош: Эпизоотологийн байдал, эмнэл зүйн шинж тэмдэг, эмгэг бие бүтцийн хувиралт зэргийг үндэслэн урьдчилсан онош тогтоох бөгөөд оношийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулна. Лабораторид эмгэгт материалыг “Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд зориулсан дээж авах, бэлтгэх, илгээх журмын” 5.1.1–д заасны дагуу авч хүргүүлнэ. Лабораторид ирүүлсэн эмгэгт дээжид вирус ялган авах болон сонгомол ба бодит хугацааны БХ–ПГУ, эсрэгтөрөгч, эсрэгбием илрүүлэх ЭЛИЗА, ВСУ зэргийг ашиглаж шинжилгээ хийнэ.

Ялгаварлан оношлох: Шүлхий өвчнийг амны хөндийн цэврүүт үрэвсэл, гахайн цэврүүт өвчин, гахайн цэврүүт экзентема, туурайн илжрэл, химийн болон халууны түлэгдэл зэргээс ялгаварлах хэрэгтэй. Мялзан, үхрийн халдварт хамар, уушигны үрэвсэл, үхрийн вируст чацга алдалт, үхрийн хорт салст халуурал, хэл хөхрөх өвчний үед үхрийн амны хөндийд илрэх шинж тэмдэг нь шүлхийн хожуу үеийн шинжтэй төсөөтэй байж болно. Хонинд хэл хөхрөх, амруу өвчний үед үзэгдэх шинж, уруул, хөлөнд гарах яршил нь шүлхийн шинж тэмдэгтэй төстэй байж болно.

7. Эмчилгээ: Хийдэггүй, шууд устгана.

8. Тэмцэх, сэргийлэх арга хэмжээ: Шүлхий гарсан аймаг, сум, баг, аж ахуйн нэгж, ферм, айл өрхөд мал эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Монгол улсын засгийн газар болон аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм хэрэгжүүлнэ.

8.1 Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэг:

8.1.1 Шүлхий өвчний гарч хорио цээр тогтоосон үед дараах бүсүүдийг тогтоож дор дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

8.1.1.1 Халдварын голомтын бүс - Өвчин гарсан сумын нутаг дэвсгэрт бэлчээр, ус нэгтэй, мал нь хоорондоо нийлэх боломжтой, ойр, саахалт байгаа хэсэг хот айлуудын аль нэгнийд нь шүлхий өвчин гарсан тохиолдолд тэдгээрийг нийтэд нь халдварын голомт хэмээн үзэж мал эмнэлгийн хорио цээрийн онцгой дэглэм тогтоож, бусад хот айлуудаас зааглан тусгаарлаж, харуул, постууд гаргаж, тухайн бүсээс хүн, мал гадагш зорчихоос хамгаалах арга хэмжээ авна.

8.1.1.2. Сэжигтэй бүс - Бэлчээр, ус тусгаар боловч халдварын голомттой хил залгаа оршдог, мал нь өвчний халдвар авсан байж болзошгүй, одоогоор малд нь өвчний ил шинж тэмдэг илрээгүй байгаа хот айлуудыг хамруулан сэжигтэй бүсийн заагийг тодорхойлж, хорио цээрийн онцгой дэглэм тогтоож, байнгын харуул, пост гарган ажиллуулна. Сэжигтэй бүсийн өргөн нь 10 км-ээс доошгүй байх бөгөөд айлуудын байршлаас шалтгаална.

8.1.1.3 хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.3.1 Явган буюу аливаа хөсгөөр гадагш зорчих;

8.1.1.3.2 Мал, амьтныг гаднаас оруулах, гадагш гаргах, дамжин өнгөрүүлэх;

8.1.1.3.3 Мал, амьтны гаралтай түүхий эд бэлтгэх, гадагш гаргах, тээвэрлэх;

8.1.1.3.4 Мал эмнэлгийн албаны зөвшөөрөлгүйгээр мал, амьтны хөдөлгөөн хийх, нутаг бэлчээр сэлгэх, ердийн хөсөг, уналгаар зорчих;

8.1.1.3.5 Өвчтэй болон эрүүл мал, амьтныг шилжүүлэх, маллах;

8.1.1.3.6 Өвчтэй мал, амьтны хашаа, байр, тоног төхөөрөмжийг бусад мал, амьтанд хэрэглэх, хашаа, байранд малын эмч, тухайн малчнаас өөр хүн оруулах.

8.1.1.3.7 Өвчтэй мал, амьтныг голомтын нутаг дэвсгэрийн гадна байгаа эрүүл мал, амьтантай бэлчээр, усаар нийлүүлэх;

8.1.1.3.8 Зөвшөөрөгдсөн цэг, зурвасаас бусад газраар голомт бүхий нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх;

8.1.1.3.9 Үзэсгэлэн гаргах, хурал цуглаан, баяр наадам хийх, хүн, мал, амьтныг олноор бөөгнөрүүлэх.

8.1.1.4 Голомтод гаднаас орох, голомтоос гарах зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүмүүсийн биеийн ил хэсгийг /нүүр, гар, толгой/ содын 4 хувийн уусмал буюу нимбэгийн хүчлийн 0.2 хувийн уусмалын аль нэгээр арчиж цэвэрлэнэ. Гадуур хувцас, тээврийн хэрэгслийг формальдегидын 16 хувийн уураар 30 минут утаж халдваргүйжүүлнэ.

8.1.1.5 Өвчлөмтгий малд өдөр бүр үзлэг хийж, өвчтэйг эрүүлээс нь яаралтай тусгаарлан зөвшөөрөгдсөн аргаар устгах, зохих зааврын дагуу халдваргүйжүүлэлт хийж, эрүүл малыг вакцинуулна.

8.1.1.6 Хамгаалалтын бүс - Голомтын болон сэжигтэй бүсээс алслагдсан, өвчний халдвар эхэлснээс хойш дээрх бүсүүдээс хүн, мал тухайн нутаг дэвсгэрт орж ирээгүй, малд нь өвчний шинж тэмдэг илрээгүй байгаа хот айлуудыг хамруулан хамгаалалтын бүсийн заагийг тодорхойлж, хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтооно. Хамгаалалтын бүсийн өргөн нь сэжигтэй бүсээс 10 км-ын зайд байх бөгөөд өдрийн цагаар харуул, пост томилон ажиллуулна.

8.1.1.6.1 Хамгаалалтын бүсэд дараах үйл ажиллагааг хориглоно:

8.1.1.6.2 Хүн, мал, амьтныг голомтын болон сэжигтэй бүсээс хамгаалалтын бүсэд нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх;

8.1.1.6.3 Хүн, мал, амьтныг хамгаалалтын бүсээс голомтын болон сэжигтэй бүсэд оруулах.

8.1.1.7 Хамгаалалтын бүсээс зайлшгүй шаардлагаар гарах, уг бүсэд оруулах тээврийн хэрэгслийн дугуйг формалины 4 хувийн уусмалаар бүрэн шүршиж халдваргүйжүүлнэ.

8.1.1.8 Эрүүл бүс - Хамгаалалтын бүсийн заагаас гадна орших, өвчний халдвар дамжаагүй нь баттай мэдэгдэж байгаа нутаг дэвсгэрийг эрүүл бүс гэж үзнэ.

8.1.1.9 Нэг сумын нутаг дэвсгэр дээр хоорондоо зайтай хэд хэдэн голомт үүссэн нөхцөлд тус бүрт нь дээрх бүсүүдийг тогтоох ба цаашид голомтууд ойртох тусам тэдгээрийг нэгтгэн нэг голомтод хамруулна. Сэжигтэй бүсийг хэд хэдэн голомтыг хамруулан нэгдсэн байдлаар зохион байгуулж болно.

8.1.1.10 Сумын нутаг дэвсгэрт олон тусдаа голомт үүссний улмаас бүхэлдээ сэжигтэй бүс болон хувирсан тохиолдолд сэжигтэй бүсийн заагийг сумын хилээр тогтоож, хорио цээрийн онцгой дэглэм хэрэгжүүлнэ.

8.1.1.11 Тогтоосон хорио цээрийн дэглэмийг устгал хийж өвчний шинж тэмдэг дахин илрээгүй, сүүлчийн вакцин тарьснаас хойш 21 хоногийн дараа бүх өвчлөмтгий малд мал эмнэлгийн үзлэг хийж өвчтэй малд хэрэглэж байсан тоног хэрэгсэл, хашаа, байр зэрэгт эцсийн халдваргүйжүүлэлт хийсний үндсэн дээр хорио цээрийн дэглэм тогтоосон байгууллага, албан тушаалтны шийдвэрээр татан буулгах;

8.1.1.12 Мал устгасан нөхөн төлбөрийн асуудлыг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж олгох;

8.1.2 Мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчийн гүйцэтгэх үүрэг:

8.1.2.1 Засаг даргын захирамжийн биелэлт, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт, зааврын биелэлтэнд хяналт тавих ;

8.1.2.2 Захирамж болон бусад холбогдох хууль эрх зүйн актыг зөрчсөн этгээдүүдэд хариуцлага тооцох ;

8.1.2.3 Мал устгал, вакцинжуулах ажлын явцад хяналт тавих

8.1.2 Мал эмнэлгийн байгууллага, малын эмчийн үүрэг:

8.1.3.1 Засаг даргын захирамжийн дагуу хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, мал бүхий иргэд, малчдад анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх, хил залгаа аймаг, сум, баг, айл өрхөд мэдэгдэх;

8.1.3.2 Өвчний байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллээр зохих шатны төрийн захиргааны байгууллагуудыг хангаж байх;

8.1.3.3 Өвчинтэй тэмцэх болон мал, амьтныг эрүүлжүүлэх арга хэмжээг зааврын дагуу зохион байгуулах, эмнэл зүйн үзлэгийг тогтмол хийж байх, малын хөдөлгөөнд хяналт тавих, эрүүл малыг голомтын бүсэд оруулахгүй байх;

8.1.3.4 Голомт, сэжигтэй болон хамгаалалтын бүсийн эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй, халуунгүй эрүүл малд сэргийлэх вакциныг зааврын дагуу тарих;

8.1.3.5 Халдварын голомтын хил хязгаарыг тогтоох, өвчин гарсан шалтгааныг судлан илрүүлэх ажлыг мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэх;

8.1.3.6 Өвчтэй, халдвар авсан, өвчний сэжигтэй мал, амьтны хашаа, байр, зогсоол, уяа, тоног хэрэгсэл, тэжээлийн үлдэгдэл зэргийг байнга халдваргүйжүүлэх;

8.1.3.7 Үхсэн болон устгах зорилгоор нядалсан мал, амьтны сэг зэмийг зааврын дагуу устгуулах;

8.1 Мал бүхий аж ахуйн нэгж, иргэн, малчны гүйцэтгэх үүрэг:

8.1.3 Хариуцсан мал эмнэлгийн байгууллага болон малын эмчид өвчний шинж тэмдэг, сэжиг илэрсэн тухай албан ёсоор мэдэгдэх ;

8.1.4 Аймаг, нийслэл, дүүрэг, сумын засаг даргын захирамж, мал эмнэлгийн байгууллага, малын эмчийн шаардлагыг бүрэн биелүүлэх;

8.1.5 Малын хашаа, хороо, байрны ариун цэвэр, эрүүл ахуйн болон технологийн дэглэмийг сахих;

8.1.6 Малын эмчийн зааварчлагын дагуу өвчтэй малын бууц, баас, тэжээлийн үлдэгдлийг шагааж устгах буюу халдваргүйжүүлэх ;

8.1.7 Өвчтэй малын арчилгаа, маллагаа, тэжээлийн нөхцлийг сайжруулж өдөр тутмын арчилгаа, маллагаа, сувилгааг гардан гүйцэтгэх ;

8.1.8 Эрүүл, өвчтэй малыг хооронд холих, малын эмчийн зөвшөөрөлгүйгээр шилжилт, хөдөлгөөн хийхгүй байх ;